



## НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Ц.Жигжиджавын гудамж 9, "Хангард ордон",  
Утас: 32-77-34, Факс: (976-11) 32-01-54,  
E-mail: ub@audit.mn; http://www.city.audit.mn

2013.02.05 № 200  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫН  
АЛБАНЫ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Ч.БАТСАЙХАН ТАНАА

### АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн дагуу Нийслэлийн агаарын чанарын албаны 2012 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгон гаргасан санхүүгийн тайлан болон холбогдох бусад тайлан, илчлэл тодруулгад Нийслэлийн аудитын газрын санхүүгийн аудитын албаны IV баг аудит хийлээ.

#### **Үүрэг хариуцлагын талаарх мэдэгдэл**

Нийслэлийн агаарын чанарын алба санхүүгийн тайлангаа Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС)-ын дагуу хугацаанд нь үнэн зөв гаргах үүрэгтэй.

Санхүүгийн тайлан УСНББОУС, Сангийн сайдаас баталсан нягтлан бодох бүртгэл, тайлагналын заавар, журмын дагуу материаллаг алдаагүй үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Нийслэлийн аудитын газрын үүрэг юм.

#### **Санал дүгнэлтийн үндэслэл**

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, Монгол Улсын Үндэсний Аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлага нь санхүүгийн тайлан материаллаг хэмжээний буруу илэрхийлэлгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитаар санхүүгийн тайлан дах дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлсийг сорилын үндсэн дээр шалгадаг. Нийслэлийн агаарын чанарын албаны удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, баримталсан бодлого, хийсэн чухал тооцоолол, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Аудитын явцад хэрэгжүүлсэн горим, сорилоор олж авсан нотлох зүйлс санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үндэслэл болсон.

1118430251

Монгол Улсын төсвийн байгууллагуудад мөрдүүлж байгаа Сангийн сайдын тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын заавар, журам нь УСНББОУС-ын заримтай нийцэхгүй байна. Тухайлбал: Төсвийн байгууллагууд санхүүгийн тайлангаа аккрузл сууриар бус, аккрузл-мөнгө хольсон сууриар тайлагнаж байхаар журамласан нь авлага, өглөг, хөрөнгө, тайлант үеийн орлого, зардал, үр дүнгийн үзүүлэлтүүд олон улсын стандартаас зөрүүтэй илэрхийлэгдэх магадлалтай.

Сангийн яамнаас нэгэнт бүх төсөвт байгууллагуудад дээрхи заавар журмыг мөрдүүлсэн учраас санхүүгийн тайланг түүнтэй нийцүүлэн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Нийслэлийн агаарын чанарын албаны 2012 оны 1 дүгээр сарын 1-нээс эхэлж мөн оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон 2012 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн санхүүгийн байдлын, санхүүгийн үр дүнгийн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний тайлангууд нь Сангийн сайдын тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой журам, зааврын дагуу материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн байна.

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Т. САРАНТУЯА